



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/365

Мөрөн сум

Цэцэрлэгийн тусгай зөвшөөрлийн
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын тухай хуулийн 23 дугаар зүйл 23.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 10 дугаар зүйлийн 10.1.5, аймгийн Боловсролын газрын дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Цагаан-Уул сумын 2 дугаар цэцэрлэгийн тусгай зөвшөөрлийг 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс 2027 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаагаар сунгасугай.
2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН